



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/24

Амардалай

Хяналтын пост ажиллуулах тухай


Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2020 оны "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн тухай" 62 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2.1.1, Улсын Онцгой комиссын даргын 2020 оны 04 дүгээр тушаал, Аймгийн Онцгой комиссын 05 дугаар хуралдааны шийдвэр, аймгийн Засаг даргын 2020 оны А/51 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Шинэ коронавирусын халдварын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хот хоорондын болон орон нутгийн зорчигч, тээврийн хөдөлгөөнийг хянах, тандалт судалгаа явуулах зорилгоор хяналтын пост ажиллуулсугай.

Хоёр: Хяналтын постод ажиллах алба хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

Гурав: Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж нэгдсэн, удирдлагаар хангаж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга /З.Наранмандах/, хэсгийн цагдаа /Б.Насанжаргал/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ИШ-ЁНДОН

4880100064